



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/06

Есөнбулаг сум

“Баялаг бүтээгчдийг дэмжих жил”
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих “Цагаан алт” үндэсний хөдөлгөөн, “Хүнсний хувьсгал хөдөлгөөн”, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, эдийн засгийн өсөлтийг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор 2026 оныг “Баялаг бүтээгчдийг дэмжих жил” болгон зарласугай.

2. Баялаг бүтээгчид, иргэд, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого боловсруулах, нэрэмжит жилийн ажлын төлөвлөгөөг гаргах, “Баялаг бүтээгчдийн зөвлөгөөн” зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Баялаг бүтээгчид, иргэн, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд хуулийн хүрээнд зөвлөн туслах, төрийн үйлчилгээг шуурхай хүргэж ажиллахыг бүх шатны төрийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж биелэлт үр дүнг тооцож, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг (М.Алтангэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:Ajil, zahiramj Zax ZD 2025

8200010014

Аймгийн Засаг даргын 2026 оны
01 дүгээр сарын 06-ны өдрийн 4 дугаар
захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	М.Алтангэрэл	(аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүдэд:	Д.Чинзориг	(Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
	Ж.Амгаланбаатар	(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
	Р.Цэнд-Аюуш	(Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
	Б.Чимэгбаяр	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэр, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга)
	Ё.Нарангарав	(Инноваци, судалгаа бизнес хөгжлийн төвийн захирал)
	Х.Энхтайван	(Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга)
	Н.Нинжбадам	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
	Р.Санжжав	(Баялаг бүтээгчдийн холбооны тэргүүн)
	Б.Мөнхдалай	(Хөдөө аж ахуй, хоршоологчдын холбооны дарга)
	Б.Нармандах	(Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн холбооны дарга)
Нарийн бичгийн дарга:	Ж.Очир	Сумдын Засаг дарга нар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)